



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/525

Зуунмод

Зардал гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эх нутгийн иргэд” ТББ, “Дүнжингаравын зураач уран бүтээлчид” ТББ “Төв сайхан нутгийн шүтээн хайрханууд” төслийн хүрээнд хамтран ажиллах гэрээ болон санамж бичигт гарын үсэг зурахаар Төв аймагт ажиллах болсон тул шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 1,008,500 (нэг сая найман мянга таван зуу) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт), Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Магнайбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР